



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 29 өдөр

Дугаар АНН

Улаанбаатар хот

Мод тарих, бэлтгэл ажил  
зохион байгуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын хооронд байгуулсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд Нийслэлд 120 саяас доошгүй мод тарьж ургуулах, хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэх, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө”-нд тусгагдсан тусгай хэрэгцээний ногоон байгууламжийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, төвлөрсөн хогийн цэгүүдэд мод тарих ажлыг зохион байгуулахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Г.Батзориг)-нд үүрэг болгосугай.

2. Энэ захирамжийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 41 дүгээр хороо, Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэг, Баянзүрх дүүргийн 21 дүгээр хороо, Цагаан давааны төвлөрсөн хогийн цэг тус бүрд ойжуулах, хамгаалалтын зурваст мод тарих бэлтгэл ажил болон тарилт хийх ажлыг үе шаттай зохион байгуулж шаардлагатай санхүүжилтийг урсгал зардлаас гарган ажиллахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ (Г.Ууганбаяр)-т, Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ (Ц.Төрхүү)-т, Геодези, усны барилга, байгууламжийн газар ОНӨААТҮГ (Б.Бямбасайхан)-т тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Г.Батзориг)-нд үүрэг даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1726030446



پہنچاؤ سیشنوں کے ذریعہ  
اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے

پاکستان

اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے کہ (پن) کے ذریعہ اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے

پن (پن) کے ذریعہ اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے

پن (پن) کے ذریعہ اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے

پن (پن) کے ذریعہ اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے

پن (پن) کے ذریعہ اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے

پن (پن) کے ذریعہ اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے

پن (پن) کے ذریعہ اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے

پن (پن) کے ذریعہ اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے

پن (پن) کے ذریعہ اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے

پن (پن) کے ذریعہ اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے

پن (پن) کے ذریعہ اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے

پن (پن) کے ذریعہ اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے

پن (پن) کے ذریعہ اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے



پن (پن) کے ذریعہ اساتذہ کرام کو اطلاع دیا گیا ہے